Батлав: САНГИЙН ЯАМНЫ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА: Ч.ЧИМИДСҮРЭН

**МОНГОЛ УЛСЫНТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН НИЙГЭМЛЭГИЙН ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2020 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2020 оны 01 сарын 13

| Гэрээний тусгай нөхцөлийн заалт | Үйл ажиллагаа | Хугацаа | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|
| 3.1.1<br>ТМЗ-д эрх олгох, сунгах сургалтын хөтөлбөр, шалгалт авах журмыг тус тус батлуулан мөрдүүлж, шалгалтыг зохион байгуулах; | 1. Татварын багц хуулийн шинэчлэлтэй холбогдуулан ТМЗН-ээс зохион байгуулагддаг сургалтуудын гарын авлага, сурах бичиг, материалд шинэчлэлт, өөрчлөлт хийж боловсруулах. | I; II улирал | Сургалтын гарын авлага, материалууд бэлтгэгдсэн байна. |
| | 2. Татварын мэргэшсэн зөвлөх /ТМЗ/ - ийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг шинэчилж боловсруулан, батлуулах | 4 сарын 15 | Мэргэшүүлэх хөтөлбөрийг хүргүүлсэн байна. |
| | 3. МУ-ын ТМЗ-д эрх олгоход бэлтгэх, эрхийг сунгах сургалтын хуваарийг жилээр гаргаж, сургалтыг зохион байгуулах. | Жилийн турш | Төлөвлөгөөний дагуу сургалтууд зохион байгуулагдсан байна. Үүнд:<br>• Эрх олгох сургалтыг 5 удаа танхимаар;<br>• Эрхийг анх удаа сунгах сургалтыг 2 удаа зохион байгуулж 40-өөс доошгүй ТМЗ гишүүдийг;<br>• Эрхийг дахин сунгах сургалтыг 2 удаа зохион байгуулж 150-аас доошгүй ТМЗ гишүүдийг тус тус хамруулан татварын хууль тогтоомж, СТОУС-ын шинэчлэл, өөрчлөлт, бүртгэл, тайлагналын талаар мэдлэгийг зохих хэмжээнд түгээсэн байна. |
| | 4. ТМЗН-ээс зохион байгуулагдах ТМЗ-ийн эрхийг 2 ба түүнээс дээш удаа сунгах сургалтыг 2, сорил шалгалтад бэлтгэх сургалтыг суралцагчдын хүсэлтэд үндэслэх, тасралтгүй боловсролын | Жилийн турш | Сургалтууд төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан байна. Суралцагчдад цаг хугацаа орон зайнаас үл хамааран суралцах боломж олгогдох болно. |

| | | | |
|---|---|---|---|
| | /модуль/ сургалтыг 4 удаа тус тус цахимаар зохион байгуулах. | | |
| | 5. ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалт авах шалгалтын бүрэлдэхүүнийг томилж, батлуулах | I улирал | ТМЗҮтХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэх хэсгийн хэрэгжилтийг хангах. |
| | 6. ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалт зохион байгуулах. | II; IV улирал | ТМЗҮтХ-ийн 18 дугаар зүйлийн 18.2.4 дэх заалтыг хэрэгжүүлэх. |
| 3.1.2 ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх; татварын мэргэшсэн зовлөхийн хуулийн этгээдийг арга зүйн удирдлага, зөвлөгөө мэдээллээр хангаж, тэдгээрийн бүртгэл. мэдээллийн санг бүрдүүлэх | 7. ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд хэрэглэгдэх ерөнхий аргачлалын журмын төслийг боловсруулах. | II; IV улирал | Үйл ажиллагаа нь тодорхой, хэмжигдэхүйц болсон байна. |
| | 8. СЯ, ТЕГ, ТМЗН хамтран ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүдэд хуулийн нөхцөл шаардлагыг хэрхэн хангаж ажиллаж байгаа талаар хяналт шалгалт хийх. | II улирал | ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн хариуцлагыг дээшлүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангасан байна. |
| | 9. СЯ-тай хамтран ТМЗҮ эрхэлж буй хуулийн этгээдийн цахим мэдээллийн санг шинэчлэх. | Жилийн турш | ТМЗҮ эрхэлж буй тусгай хуулийн этгээдийн нэгдсэн цахим мэдээллийн сан шинэчлэгдсэн байна. |
| | 10. СЯ, ТМЗН хамтран ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд семинар, сургалт зохион байгуулах. | Хагас жил тутам | Сургалт зохион байгуулагдсан байна. |
| | 11. ТМЗҮ-г тусгай зөвшөөрөлгүй эрхэлж буй хуулийн этгээдүүдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулах тухай санал СЯ-нд хүргүүлэх. | III; IV улирал | Холбогдох төрийн байгууллагатай хамтран ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөлгүй эрхэлсэн хуулийн этгээдэд хуулийн дагуу мэдэгдэж, зөрчлийг арилгах арга хэмжээ авсан байна. |
| | 12. ТМЗҮ тусгай зөвшөөрөл нь Хүчингүй болсон хуулийн этгээдүүдийн нэрнээс "ТМЗ" үгийг хасах ажлыг зохион байгуулах | Жилийн турш | Зөвхөн ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд мэдээллийн системд байрлах, олон нийтэд зарлаж, иргэд, аж ахуйн нэгжүүд ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй компанит итгэх итгэл нэмэгдэх бөгөөд үүнийг дагаад ТМЗ-ийн хуулийн этгээдүүдийн хариуцлага нэмэгдэнэ. |
| 3.1.3 Мэргэжлийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэнд | 13. ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон хуулийн этгээдүүдийн нэрээс "ТМЗ" үгийг хасах ажлыг зохион байгуулах, | | Зөрчил гаргасан хуулийн этгээд, гишүүдийн зөрчлийг арилгах, шаардлагатай тохиолдолд эрхийг нь түдгэлзүүлэх, хүчингүй болгуулах |

| | | | |
|---|---|---|---|
| хяналт тавих, татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгуулах саналыг Захиалагчид тавьж шийдвэрлүүлэх | | Жилийн турш | саналыг холбогдох этгээдэд хүргүүлж шийдвэрлүүлсэн байна. |
| 3.1.5<br>Шалгалтын тестийн сан бүрдүүлэх. татварын чиглэлийн олон улсын бичиг баримт орчуулах, тайлбарлах, зөвлөмж боловсруулах, судалгааны ажил хэрэгжүүлэх; | 14. ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалтын тестийн санг цахимжуулах, шалгалт зохион байгуулагдах бүрд хичээл тус бүрээр нэмэгдүүлэх. | II; IV улирал | • ТМЗ-ийн эрх сунгах шалгалт (анх болон дахин), ТМЗ-д эрх олгох шалгалтын Хууль эрх зүй, татварын бүртгэл хичээлийн шалгалтын тестийн санг бүрэн шинэчлэх, хичээл тус бүрээр 100-150 тест;<br>• НББОУСХ хичээл -20 асуулт, 10 бодлого;<br>• Татварын онол – 20 асуултаар тестийн санг тус тус нэмэгдүүлж, шинэчилсэн байна. |
| | 15. Нягтлан бодогч мэргэжлээр /бакалавр, магистр, доктор/ төгсч байгаа мэргэжилтэнд тавигдах шаардлагыг судлаж, судалгааны үр дүнг танилцуулах | 4 сарын 15 | Судалгааны үр дүнг хүргүүлсэн байна. |

БОЛОВСРУУЛСАН:

ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН НИЙГЭМЛЭГИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: Ц.БОЛОРМАА

ХТ00343 1045822

ХЯНАСАН:

САНГИЙН ЯАМНЫ НБББГ-ЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН: Б.БОЛОРМАА

31/I 2020